



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/254

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4 дэх заалт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны А/737 тушаалаар батлагдсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэсэн талбайг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Мөнх-Оргил

Хэнтий шинэс сум дундын ойн
ангийн дарга

Гишүүд: Т.Чинхуяг

Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

С.Ууганбаяр

Байгаль хамгаалагч

2.Үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэсэн талбайг хүлээн авч “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу гүйцэтгэлийн акт үйлдэхийг ажлын хэсгийн ахлагч /Г.Мөнх-Оргил/-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2324100578